



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/235

Мандалговь

Говийн бүсийн аймгуудын ахмадын  
спортын наадам зохион байгуулах тухай

Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалтууд, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 3.3.2 дахь заалт, "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.5, 2.1.6 дахь заалтууд, аймгийн Засаг даргын 2017 оны А/492 дугаар захирамжаар батлагдсан Ахмад настны талаар 2018-2021 онд баримтлах бодлогын 5.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Ахмад настны эрүүл насжилтыг дэмжих, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг олон түмэнд сурталчилж, говийн бүсийн ахмад тамирчдыг харилцан туршлага солилцуулах зорилгоор говийн бүсийн аймгуудын ахмадын спортын наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: С.Хулан (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ц.Сугир (Аймгийн Ахмадын хорооны дарга)

М.Наранбадрах (БТСГ-ын дарга)

С.Цолмон (БТСГ-ын мэргэжилтэн)

Д.Доржсүрэн (ТХДЖТ-ын дарга)


Д.Баярмаа (Аймгийн ЗДТГ-ын олон нийттэй харилцах ажилтан)

Хоёр. Говийн бүсийн аймгуудын ахмадын спортын наадмын удирдамжийг хавсралтаар баталсугай.

Гурав. Говийн бүсийн аймгуудын ахмадын спортын наадмыг 2019 оны 6 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд удирдамжийн дагуу бэлтгэл зохион байгуулалттай явуулж, үр дүнг 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор багтаан тайлагнахыг ажлын хэсгийн дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

Дөрөв. Говийн бүсийн аймгуудын ахмадын спортын наадмын дэмжлэгт зориулж 1000000 (Нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

433190618

Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын  
05-ны өдрийн 235 дугаар захирамжийн  
хавсралт

**ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН АХМАДЫН СПОРТЫН  
НААДМЫН УДИРДАМЖ**

**Нэг: Тэмцээний зорилго**

Дундговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ахмад настны эрүүл насжилтыг дэмжих, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтийн биеийн тамир, спортыг олон түмэнд сурталчилж, говийн бүсийн ахмад тамирчдыг харилцан туршлага солилцуулах, хүүхэд залууст үлгэр дууриал үзүүлэхэд оршино.

**Хоёр: Тэмцээний удирдлага, зохион байгуулалт**

Тэмцээнийг аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг, томилогдсон шүүгчид, төрөл хариуцсан спортын холбоод зохион байгуулж явуулна. Тэмцээнд эрэгтэй 60, эмэгтэй 55 ба түүнээс дээш настай ахмад тамирчид оролцоно.

Тэмцээнд оролцох аймгуудын ахмад тамирчид өөрийн аймгийн туг, лого болон тоглолтын хувцасаар жигдэрч оролцоно.

Тэмцээнд оролцох баг, тамирчдын мэдүүлгийг 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 15.00 цагт аймгийн Ахмадын хороонд ирүүлсэн байна.

Тэмцээнд оролцох аймгуудын эрхийн төлбөр 300000 /Гурван зуун мянга/ төгрөг байна.

Тамирчид иргэний үнэмлэхээрээ мандат авна. Мандатны үнэ 5000 төгрөг байна. Мандатыг мэдүүлгийн дагуу нэгдсэн журмаар Дундговь аймгийн Ахмадын хороон дээр олгоно. Тамирчид иргэний үнэмлэх, 1 хувь цээж зурагтай ирнэ.

Тэмцээнд оролцох баг тамирчид байр, хоол, унааны зардлаа өөрсдөө хариуцана.

### **Гурав: Хугацаа**

Тэмцээнийг 2019 оны 06 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Дундговь аймгийн төвд зохион байгуулна.

Техникийн зөвлөгөөнийг 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 16.00 цагт аймгийн ЗДТГ-ын нэг давхарын хурлын зааланд шүүгчдийн бүрэлдэхүүнтэй хийж тэмцээн явагдах заал, танхимийг танилцуулна.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагааг аймгийн төв талбайд 2019 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 10.00 цагт хийнэ.

### **Дөрөв: Тэмцээний төрөл**

Тэмцээн спортын дараах төрлүүдээр явагдана.

- Волейбол / эрэгтэй 4, эмэгтэй 4 / нийт 8 тамирчин
- Шатар / эрэгтэй 1, эмэгтэй 1 / нийт 2 тамирчин
- Дардас / эрэгтэй 1, эмэгтэй 1 / нийт 2 тамирчин
- Шагайн харваа / багт 6 хүнтэй /
- Ширээний теннис / эрэгтэй 1, эмэгтэй 1 / ганцаарчилсан, холимог хос гэсэн төрлөөр явагдах ба тамирчин нэг л төрөлд оролцоно.

### **Тав: Тэмцээнийг дүгнэх журам, шагнал, урамшуулал**

Тэмцээний төрөл тус бүр дээр 1, 2, 3 дугаар байр эзлүүлж шалгаруулна.

Тэмцээнийг төрөл тус бүрээр бага онооны системээр байр эзлүүлж, нийлбэр дүнг гарган аймгуудын нэгдсэн дүнгээр байр эзлүүлнэ.

Багийн дүнгээр: Тэргүүн байр-1

Дэд байр-1

Гутгаар байр-1 тус тус шалгаруулан байр эзлүүлнэ.

**ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**